

Mongol - Эхнэрүүд Судрууд - Wives Scriptures

Ефес 5:22-24 Эхнэрүүд ээ, Эзэнд захирагддаг шиг нөхрүүддээ захирагд. 23 Учир нь Христ чуулганы толгой байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ толгой юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн. 24 Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд.

Ефес 5:31,33 "Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно". 33 Та нарын нэг бүр чинь өөрийгөө хайрладгийн адил эхнэрээ хайрла. Эхнэр нь нөхрөөсөө эмээж бай.

1 Коринт 7:3 Нөхөр нь эхнэрийнхээ өмнө өөрийн үүргээ биелүүлэг. Үүнчлэн эхнэр нь мөн нөхрийнхөө өмнө өөрийн үүргээ биелүүлэг.

1 Коринт 7:34 тэр хүн хуваагдсан байдаг аж. Гэрлээгүй онгон эмэгтэй нь биеэрээ болон сүнсээрээ ариун байхын тулд Эзэний юмсад санаа тавьдаг. Харин гэрлэсэн эмэгтэй нь нөхөртөө яаж таалагдах вэ хэмээн ертөнцийн юмсад санаа тавьдаг юм.

Колоссай 3:18 Эхнэрүүд ээ, Эзэний тааладд нийцүүлж нөхөртөө захирагдагтун.

1 Тимот 2:11-15 Эмэгтэй хүн дуугүй байн, бүрэн дуулгавартайгаар суралц. 12 Харин эмэгтэй хүн заах, эсвэл эр хүнийг захирах эрх мэдэлтэй байхыг би зөвшөөрөхгүй. Харин дуугүй байхыг зөвшөөрдөг. 13 Учир нь эхлээд Адам, дараа нь Ева бүтээгдсэн билээ. 14 Адам мэхлэгдээгүй. Харин эмэгтэй нь мэхлэгдэж, гэм буруу дотор унасан юм. 15 Гэвч хэрэв эмэгтэйчүүд итгэл, хайр дотор ба зохистой байн ариусал дотор цаашид байх аваас эмэгтэй нь хүүхэд төрүүлэхээрээ аврагдана.

Эхлэл 3:16 бас эмэгтэйд — Би чиний жирэмсний зовлонг үлэмж ихэсгэж, Чи их зовлонтойгоор хүүхэд төрүүлэх болно. Чи эр нөхрийг хүсэн мөрөөдөж, Эр нөхөр чинь чамайг захирна гэв.

1 Петр 3:1,2 Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд үггүйгээр, эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана. 2 Тэд та нарын журамт байдал болоод эелдэг зан байдлыг чинь ажиглана шүү дээ.

Тит 2:1-5 Харин чи эрүүл сургаалд тохирох зүйлсийг ярь. 2 Настай эрчүүд биеэ барьдаг, хүндэтгэлтэй, ухаалаг, итгэл, хайр, тэвчээр дотор эрүүл байх ёстой. 3 Настай эмэгтэйчүүд зан байдлаараа хүндлүүштэй байж, хов жив ярилгүй, дарсанд хэт боолчлогдолгүй, юу сайн болохыг заах ёстой. 4 Ингэснээр тэд залуу эмэгтэйчүүдийг нөхөр ба хүүхдүүдээ хайрладаг, 5 нөхөртөө захирагдан ухаалаг, цэвэр, гэрийн эзэгтэй, энэрэнгүй байхад сургах юм. Тэгвэл Бурханы үг муу хэлэгдэхгүй.

Сургаалт үгс 12:4 Сайн эхнэр нөхөртөө титэм юм. Харин нөхрөө ичгүүрт оруулдаг эхнэр түүний ясан дахь идээ бээр мэт буюу.

Сургаалт үгс 14:1 Мэргэн эмэгтэй орон гэрээ төвхнүүлдэг бол Мунхаг

эмэгтэй өөрийн гараар орон гэрээ нураадаг.

Сургаалт үгс 19:13 Мунхаг хөвгүүн эцгийнхээ сүйрэл нь юм. Хэрүүлч эхнэр тасралтгүй дуслах устай адил буюу.

Сургаалт үгс 21:9,19 Хэрүүлч эхнэрийн хамт байшинг хуваалцан сууснаас Дээврийн буланд амьдарсан нь дээр. 19 Хэрүүлч, уур уцаартай эмэгтэйтэй хамт байснаас цөлд амьдарсан нь дээр.

Сургаалт үгс 25:24 Хэрүүлч эхнэрийн хамт байшинг хуваалцан сууснаас дээврийн буланд амьдарсан нь хавыүй дээр.

Сургаалт үгс 27:15,16 Гэмэргэн эм болбоос бороошсон өдөр ус тасралтгүй дуслахтай адил буюу. 16 Тийм эмэгтэйг номхтгох нь салхийг зогсоох болон гараараа тосыг атгаж авахтай адил буюу.

Сургаалт үгс 31:10-31 Хэн арван хуруу тэгш эхнэр олж чадах вэ? Тийм эхнэр эрдэнэсээс ч үнэтэй. 11 Нөхөр нь түүнд бүрэн итгэх бөгөөд юутаар ч үл дутна. 12 Тэр бүх л амьдралынхаа турш нөхөртөө мууг бус, зөвхөн сайныг л үйлддэг. 13 Ноос ба маалинган даавууг тэр сонгон авч, гараа хумхилгүй ажилладаг. 14 Худалдаачны хөлөг онгоцнууд мэт тэр хоол хүнсээ хол газраас зөөдөг. 15 Тэр үүр цайхаас өмнө босож, гэр бүлдээ унд цайг бэлтгэж, Шивэгчин бүсгүйчүүлдээ хийх ёстойг нь хуваарилдаг. 16 Тэр газрыг үзээд, худалдан авч, Орлогоороо усан үзмийн мод тариалдаг. 17 Тэр ажилдаа хичээнгүй, шаламгай бөгөөд Түүний гар улам хүчтэй болно. 18 Ажил үйлс нь бүтэмжтэй байгаад тэр урамшина. Дэнлүү нь шөнөжингөө асдаг. 19 Гартаа ээрүүл барьж, хуруугаараа шаламгай ажиллана. 20 Ядуу хүнд гараа сунгадаг. Гачигдаж дутагдсан хүмүүст тусалдаг. 21 Цас хаялахад гэр бүлийнхээ төлөө санаа зовох зүйлгүй байдаг. Учир нь гэрийнхэн нь дулаан хувцсаар хангагдсан билээ. 22 Тэр орондоо бүтээлэг урлаж, Ёрог даавуун ба нил ягаан өнгөтэй хувцас өмссөн байдаг. 23 Нөхөр нь хотын дааман хаалган дээр нутгийн ахлагч нарын дунд сууж байхдаа хүндлэгддэг. 24 Тэр ёрог даавуун дээл хийж, худалддаг бөгөөд Бес даавууг худааддаачдад нийлүүлдэг. 25 Тэр хүч чадал ба хүндэтгэлээр хувцасласан бөгөөд Инээмсэглэлээр ирээдүйгээ утана. 26 Тэр мэргэн үгээр ярьж, энэрлийг сургадаг. 27 Тэр гэр орондоо санаа тавих бөгөөд залхуурахыг үл мэднэ. 28 Үр хүүхдүүд нь өсөж өндийгөөд, түүнийг ерөөнө. Эр нөхөр нь ч гэсэн түүнийг магтан 29 "Олон эмэгтэйчүүд сайн үйл хийдэг ч чи тэднээс илүү билээ" хэмээнэ. 30 Дур булаам байдал хуурамч бөгөөд гоо үзэсгэлэн ч хоосон. Харин ЭЗЭНээс эмээгч эмэгтэй л магтаал авах учиртай. 31 Ажил үйлсийнх нь үр жимсийг түүнд өг. Ажил үйлс нь дааман хаалган дээр түүнд хүндэтгэлийг авчрах болтугай.